



# **СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК**

Монголын МНБИ болон ТМЗН-ийн гишүүн байгууллага

## **“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК**

(Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31

Улаанбаатар хот

2020 он



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ний  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,  
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот  
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;  
Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2020.03.20 № СТА/20-46  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Дүгнэлт

Бид “Баянгол Зочид Буудал” ХК-ний 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн чухал бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бид “Баянгол Зочид Буудал” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн зөв, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЭЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

### Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байна. Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

## **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

### **Баянгол Зочид Буудал ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)**

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

### **Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

### **Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм.

Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Баянгол Зочид Буудал ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага (үргэлжлэл)

- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бүр тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог.

Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоонд суурилна. Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг бид бүхэлд нь үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай зөвхөн аудитын ажлын хамрах хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудын талаар харилцсан.

### Бусад хууль эрх зүйн шаардлагуудын талаарх тайлан

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 92 болон 94-р зүйлийн дагуу бид дараах тохиолдлуудад та бүхэнд тайлагнах үүрэгтэй:

- Сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ;
- Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалттай холбоотой зөрчил;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон мэдээлэл; болон
- Компанийн дүрмийн дагуу болон аудитын гэрээний дагуу шаардагдах бусад мэдээлэл

Дээрх зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

**СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК**  
Мэргэшсэн нягтлан бодогчид

Монгол Улс, Улаанбаатар хот  
Огноо: 2020 оны 3 сарын 20



**Д.АЛТАНЦЭЦЭГ**  
Захирал, МНБ

“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/мянган төгрөг/

	<u>Тодруулга</u>	<u>2018.12.31</u>	<u>2019.12.31</u>
<b><u>Эргэлтийн хөрөнгө</u></b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5	15,777,310.9	11,330,014.4
Дансны авлага	6	703,093.7	548,454.3
Татвар НДШ-ийн авлага		3,717.3	3,389.7
Бусад авлага	6	14,706,429.9	12,424,120.1
Бараа материал	8	1,076,596.5	1,096,040.3
<b><u>Эргэлтийн хөрөнгийн дүн</u></b>		<b><u>32,267,148.3</u></b>	<b><u>25,402,018.8</u></b>
Үндсэн хөрөнгө	10	4,171,704.3	5,008,114.7
Урт хугацаат хөрөнгө оруулалт		2,335,307.5	2,335,307.5
<b><u>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</u></b>		<b><u>6,507,011.8</u></b>	<b><u>7,343,422.2</u></b>
<b><u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u></b>		<b><u>38,774,160.1</u></b>	<b><u>32,745,441.0</u></b>
Дансны өглөг	13	494,807.2	262,718.8
Цалингийн өглөг		33,292.0	43,881.5
Татварын өр	22.2	114,691.5	91,022.1
НДШ-ийн өглөг			1,476.9
Богино хугацаат зээл	15	5,557,132.0	
Ногдол ашгийн өглөг		440,099.3	181,258.8
Бусад богино хугацаат өр төлбөр		4,742.2	4,494.0
<b><u>Богино хугацаат өр төлбөрийн дүн</u></b>		<b><u>6,644,764.2</u></b>	<b><u>584,852.1</u></b>
Урт хугацаат зээл			
<b><u>Урт хугацаат өр төлбөрийн дүн</u></b>			
<b><u>Нийт өр төлбөрийн дүн</u></b>		<b><u>6,644,764.2</u></b>	<b><u>584,852.1</u></b>
Хувийн өмч /хувьцаат/	17	54,998.5	54,998.5
Халаасны хувьцаа	17	67,212.9	67,212.9
Нэмж төлөгдсөн капитал		102,280.6	102,280.6
Хуримтлагдсан ашиг		32,039,329.7	32,070,522.7
<b><u>Эздийн өмчийн дүн</u></b>		<b><u>32,129,395.9</u></b>	<b><u>32,160,588.9</u></b>
<b><u>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</u></b>		<b><u>38,774,160.1</u></b>	<b><u>32,745,441.0</u></b>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

/мянган төгрөгөөр/

<u>Үзүүлэлт</u>	<u>Тодруулга</u>	<u>2018.12.31</u>	<u>2019.12.31</u>
<b><u>Борлуулалтын орлого (цэвэр)</u></b>	23.1	<b><u>6,847,102.0</u></b>	<b><u>6,722,551.9</u></b>
Борлуулалтын өртөг	23.2	3,301,921.3	3,831,480.0
<b><u>Нийт ашиг /алдагдал/</u></b>		<b><u>3,545,180.7</u></b>	<b><u>2,891,071.9</u></b>
Түрээсийн орлого		444,403.9	387,651.5
Хүүний орлого		240,390.5	261,112.9
Бусад орлого	24	55,554.4	19,785.6
Борлуулалт, маркетингийн зардал	23.3	1,200,675.1	1,426,666.3
Ерөнхий ба удирдлагын зардал			
Санхүүгийн зардал			
Бусад зардал		198,087.3	124,789.7
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	21	854,851.1	322,882.0
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Бусад ашиг (алдагдал)			
<b><u>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</u></b>		<b><u>3,741,618.2</u></b>	<b><u>2,331,047.9</u></b>
Орлогын татварын зардал	22	308,485.4	213,295.6
<b><u>Татварын дараах ашиг (алдагдал)</u></b>		<b><u>3,433,132.8</u></b>	<b><u>2,117,752.3</u></b>
<b>Орлогын нийт дүн</b>		<b>3,433,132.8</b>	<b>2,117,752.3</b>
<b><u>Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)</u></b>			

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ”ХК

2019 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b><u>2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</u></b>	<b><u>54,998.5</u></b>	<b><u>67,212.9</u></b>	<b><u>102,280.6</u></b>	<b><u>28,741,499.1</u></b>	<b><u>28,831,565.3</u></b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын Өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
<b>Залруулсан үлдэгдэл</b>	54,998.5	67,212.9	102,280.6	28,741,499.1	28,831,565.3
Тайлант үеийн * цэвэр ашиг (алдагдал)				3,433,132.8	3,433,132.8
Зарласан ногдол ашиг				135,302.2	135,302.2
<b><u>2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</u></b>	<b><u>54,998.5</u></b>	<b><u>67,212.9</u></b>	<b><u>102,280.6</u></b>	<b><u>32,039,329.7</u></b>	<b><u>32,129,395.9</u></b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын Өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
<b>Залруулсан үлдэгдэл</b>	54,998.5	67,212.9	102,280.6	32,039,329.7	32,263,821.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын Өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				2,117,752.3	2,117,752.3
Өмчид гарсан өөрчлөлт				-1,951,257.1	-1,951,257.1
Зарласан ногдол ашиг				135,302.2	135,302.2
<b><u>2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</u></b>	<b><u>54,998.5</u></b>	<b><u>67,212.9</u></b>	<b><u>102,280.6</u></b>	<b><u>32,070,522.7</u></b>	<b><u>32,160,588.9</u></b>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК

2019 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/мянган төгрөгөөр/

<b><u>ҮЗҮҮЛЭЛТ</u></b>	<b><u>2018.12.31</u></b>	<b><u>2019.12.31</u></b>
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b><u>7,606,228.7</u></b>	<b><u>7,706,080.6</u></b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,606,228.7	7,706,080.6
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Бусад мөнгөн орлого		
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b><u>5,021,808.1</u></b>	<b><u>7,446,057.0</u></b>
Ажиллагчдад төлсөн	1,474,736.7	1,415,105.6
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	412,607.0	461,582.3
Бараа материал худалдан авахад төлсөн	1,559,406.0	3,980,467.1
Ашиглалтын зардалд төлсөн	328,186.9	386,820.9
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	148,480.7	284,281.6
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	1,098,509.9	913,947.1
Даатгалын төлбөрт төлсөн	1,880.9	3,852.4
Бусад мөнгөн зарлага		
<b><u>ҮҮАжиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний</u></b>	<b><u>2,584,420.6</u></b>	<b><u>260,023.6</u></b>
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b><u>3,309,455.7</u></b>	<b><u>2,549,035.5</u></b>
Хүлээн авсан хүүний орлого	240,390.6	261,112.9
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаалт	3,069,065.1	2,287,922.6
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
<b><u>ХО-ын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</u></b>	<b><u>3,309,455.7</u></b>	<b><u>2,549,035.5</u></b>
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b><u>7,914.0</u></b>	<b><u>7,579,237.6</u></b>
Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		7,563,276.0
Төлсөн ногдол ашиг	7,914.0	15,961.6
<b><u>СҮАжиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u></b>	<b><u>(7,914.0)</u></b>	<b><u>(7,579,237.6)</u></b>
<b><u>Валютын ханшийн зөрүү</u></b>	<b><u>854,851.1</u></b>	<b><u>322,882.0</u></b>
<b><u>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</u></b>	<b><u>6,740,813.4</u></b>	<b><u>(4,447,296.5)</u></b>
<b><u>Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u></b>	<b><u>9,036,497.5</u></b>	<b><u>15,777,310.9</u></b>
<b><u>Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u></b>	<b><u>15,777,310.9</u></b>	<b><u>11,330,014.4</u></b>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.



## “БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК

2019 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

### 1. КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

“Баянгол Зочид Буудал” ХК (цаашид “Компани” гэх) нь 2006 онд Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан. Компанийн голлох хувьцаа эзэмшигчид нь Х.Цэндбаяр, Х.Баттуул, Билли нар болно.

Компани 2018 болон 2019 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилд Гадаад худалдаа, Зочид буудал, Валют солих цэг ажиллуулах, Зоогийн газар, Баарын үйл ажиллагааны чиглэлээр байгуулагдсан бөгөөд тус зочид буудал нь 360 орчим зочин хүлээн авах, таван ангиллын 211 өрөөтэй, Баянгол ресторан нь 300-450 зочин зэрэг хүлээн авах хүчин чадалтай, үндэсний хоолоор үйлчлэх Монголын нэг өдөр ресторан, дээд зэрэглэлийн виноны Wine House кафе-баараар үйлчлэхээс гадна 20 гаруй төрлийн дагалдах үйлчилгээ үзүүлдэг байна.

Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-5 өөрийн байранд гэсэн албан ёсны хаяг дээр үйл ажиллагаагаа явуулдаг.

УБ-ийн гэрчилгээ: 9010001010 тоот

Регистрийн дугаар: 2026899 тоот

**Өмчийн хэлбэр:** Компани нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг 1366 гишүүнтэй байгууллага. Дүрмийн сан 54,998.5 мянган төгрөг ба халаасны хувьцаа 67,212.9 мянган төгрөг, нэмж төлөгдсөн капитал 102,280.6 мянган төгрөгийн хувьцаатай байна.

**Тайланг хамарсан хугацаа:** 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс 2019 оны 12 дугаар сарын 31

### 2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ХУРААНГУЙ**

#### 2.1 **Мөрдсөн стандарт**

Компанийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын (СТОУС) дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

#### 2.2 **Тайлан бэлтгэх үндэслэл тайлангийн суурь**

Компанийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын (СТОУС) дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

Санхүүгийн тайланг зарим үндсэн хөрөнгөөс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт зарчимд үндэслэн бэлтгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байдаг.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Компанийн үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн. Бүх санхүүгийн мэдээллийг өөрөөр заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлсэн.

#### 2.3 **Үйл ажиллагааны ба толилуулгын валют**

Санхүүгийн тайлангуудыг Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн. Аудитлагдсан санхүүгийн тайланд тусгагдсан бүх санхүүгийн үзүүлэлтүүд нь

## “БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК

2019 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

### 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн. Аудитлагдсан санхүүгийн тайланг бэлтгэхдээ өмнөх оны аудитлагдсан үлдэгдэлтэй зэрэгцүүлсэн.

#### 2.4 Тасралтгүй байх зарчим

2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Компанийн цэвэр эргэлтийн хөрөнгө нь 24,817,166.7 мянган төгрөг байна. Компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадвар нь ирээдүйн ашигтай үйл ажиллагаа, эерэг мөнгөн урсгал ба эсвэл хувь нийлүүлэгчдээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх эсэхээс хамаарна. Компанийн хөрөнгө оруулагчдын зүгээс Компанийг хүрэлцэхүйц мөнгөн хөрөнгөөр хангах учраас Компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх болно гэсэн төсөөллийн үндсэн дээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэсэн.

#### 2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогод орсон өөрчлөлт

Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өмнөх жилийн санхүүгийн тайлантай уялдуулан батлах бөгөөд дараах стандарт, нэмэлт өөрчлөлт нь 2019 оны 1-р сарын 1-ны өдрийн байдлаар хүчин төгөлдөр болно. Шинэ болон нэмэлт өөрчлөлт оруулсан стандарт & тайлбар:

- СТОУС 9 : Санхүүгийн хэрэгсэл
- СТОУС 15 : Үйлчилүүлэгчтэй байгуулсан гэрээний орлого
- СТОУС тайлбар 22: Гадаад валютын шилжүүлэг болон урьдчилаа
- нөхөн төлбөр

Стандарт олгогдсон хэдий ч хараахан хүчин төгөлдөр болоогүй:

Стандарт тайлбар олгогдсон хэдий ч компанийн санхүүгийн тайлан олгосон өдөр хүртэл хараахан хүчин төгөлдөр болоогүй бөгөөд дараах байдлаар илэрхийлсэн. Хэрэв боломжтой бол хүчин төгөлдөр болтол компани эдгээр стандартуудыг батлаж болно

- СТОУС 16 : Түрээс<sup>2</sup>
- СТОУС 17 : Даатгалын гэрээ<sup>3</sup>
- СТОУС 10 болон
- НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлт: Хөрөнгө оруулагч болон түүний хараат Компани эсвэл хамтарсан хэлцэл хоородын хөрөнгө борлуулалтын хувь<sup>4</sup>
- СТОУС 9-ын нэмэлт өөрчлөлт : Санхүүгийн хэрэглүүр<sup>1</sup>
- НББОУС 19-ын нэмэлт өөрчлөлт: Төлбөр тооцооны хасалт буюу нэмэлт
- 2015-2018 оны жилийн сайжруулалт: 2017 оны 12 дугаар сард оруулсан хэд хэдэн нэмэлт өөрчлөлтүүд

<sup>1</sup> 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр байна.

<sup>2</sup> 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр байна

<sup>3</sup> Энэ нэмэлт өөрчлөлтийн хүчин төгөлдөр болох огноог нягтлан бодох бүртгэлийн өмч хөрөнгийн ОУНББСА-ны судалгааны төслийн хүлээгдэж буй үр дүнгээс хамааран сунгана.